

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

I. Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын эдийн засгийн өсөлттэй шууд холбоо бүхий бизнесийн орчин, гадаадын хөрөнгө оруулалт, экспортын төрөлжилтийг нэмэгдүүлэхэд зангилаа асуудал болох салбарын өрсөлдөөний бодлого, зохицуулалт, худалдааны гэрээ хэлэлцээр, урсгал, түүний бүртгэлжүүлэлт болон нөхцөл байдлын шинжилгээ, чиг хандлагыг Алсын хараа 2050, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, бусад бодлогын баримт бичигтэй уялдуудан эдийн засгийн салбаруудын өрсөлдөөний чиг хандлагыг тодорхойлон, хувийн хэвшлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжих боломж болон эдийн засаг дахь худалдааны бодлогыг бусад салбаруудтай нийцтэйгээр тодорхойлон эрх зүйн боломжийг бүрдүүлэх, холбогдох хуулиудын мандатын шинжилгээ гүйцэтгэх хэрэгцээ, шаардлага үүссэн болно.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан төрийн худалдан ажиллагааны бодлогыг шинэчилж, тогтолцоог оновчтой болгох, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, чанарыг эрхэмлэсэн сонгон шалгаруулалтын зарчмыг нэмэгдүүлэх зохицуулалт бүхий хууль, эрхзүйн орчны бүрдүүлэх шаардлага байна.

Дээрх үндэслэл бүхий хэрэгцээ, шаардлагад нийцүүлж Худалдааны хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг тус тус шинэчилж сайжруулах, бодлогын баримт бичиг боловсруулах, судалгаа шинжилгээ хийх, олон нийтэд таниулан сурталчлах, гадаад улсын туршлагаас судлах зөвлөх үйлчилгээний ажлыг зарлаж байна.

II. Ажлын цар хүрээ

Зөвлөх үйлчилгээний хүрээнд Монгол улсын салбарын өрсөлдөөн, худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын нөхцөл байдлыг олон улсын жишгээр тодорхойлон, үндэсний үнэ цэнийн байршилд тулгуурлан экспортын төрөлжилтийг нэмэгдүүлэх, дотоодын боловсруулах үйлдвэрлэлийн өртгийн сүлжээг бүтээмжид суурьлан хөгжүүлэх цогц бодлого боловсруулахдаа урьд нь хэрэгжиж байсан хууль, бодлогын баримт бичгүүд болон Монгол Улсын олон улсын гэрээ, Дэлхийн худалдааны байгууллага гэх зэрэг хэлэлцээрүүдийн зарчим, дүрэм, журамд нийцүүлэн гадаад орнуудтай харилцан ашигтай хамтран ажиллах, үндэсний эдийн засгаа хамгаалах, худалдааны бодлогыг дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлоготой уялдуулах, дотоодын зах зээлийг шудрага бус өрсөлдөөнөөс хамгаалах, төрийн болон хувийн секторын худалдаа, худалдан авалтын үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх, салбаруудын тогтвортой хөгжлийг хангах, улмаар салбарын эдийн засагт үзүүлэх нөлөө, үр ашгийг нэмэгдүүлэх эрх зүйн орчинг бий болгох цогц зөвлөх үйлчилгээний ажлыг зарлаж байна.

Зөвлөх үйлчилгээний хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны эрх зүйн орчинд бодлогын судалгаа хийх, эрх зүйн орчны үнэлгээ хийх, бодлогын зөвлөмж боловсруулах, сургалт, хэлэлцүүлгүүд зохион байгуулах, гадаад улсын туршлага судлах, гадны мэргэжилтэн урьж ажиллуулах, хууль, эрх зүйн орчны баримт бичгийн боловсруулалт хийж Засгийн газарт танилцуулахад бэлэн болгоно.

Зөвлөх үйлчилгээний үр дүнд гадаад, дотоод зөвлөхүүдийн хамтын ажиллагаанд суурилсан салбаруудын өрсөлдөөний бодлого, хөрөнгө оруулалтын бодлого, худалдааны бодлого, төрийн худалдан авалтын бодлого, зохицуулалт бүхий хууль, эрх зүйн орчны баримт бичгийн боловсруулалт хийгдэж Захиалагч хянан баталгаажуулсны үндсэн дээр Засгийн газарт өргөн мэдүүлэхэд бэлэн болсон байна.

III. Хэрэгжүүлэх ажлын үе шат

3.1 Салбарын өрсөлдөөний бодлого зохицуулалт

| № | Зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа |
|--|--|-----------------------------|
| А. Дүн шинжилгээ, судалгаа, тооцоолол хийж тулгамдсан асуудлыг илрүүлэх, шийдвэрлэх хувилбаруудыг тодорхойлох | | |
| 1. | Өрсөлдөөний бодлого, зохицуулалт болон монополын эсрэг эрх зүйн харилцаа, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин, худалдааны зохицуулалтууд, төрийн худалдан авах ажиллагааны холбогдох хууль, тогтоомжууд, бодлогын баримт бичгүүд дээр дүн шинжилгээ хийх | Гэрээ хийсний 3 долоо хоног |
| 2. | Өрсөлдөөн, худалдаа, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны эрх зүйн орчны шинэчлэл дээр ижил төстэй орнуудад амжилттай хэрэгжсэн туршлагаудын харьцуулсан судалгаа гүйцэтгэх | |
| 3. | Олон улсын туршлагыг судлах хүрээнд танилцах аялал зохион байгуулах | |
| 4. | Өрсөлдөөн, худалдаа, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулах бодлогын зөвлөмжүүд боловсруулах, авч хэрэгжүүлэх боломжит арга хэмжээний хувилбаруудыг боловсруулах | |
| Б. Эрх зүйн хүрээнд хийх шинэчлэлийг иргэд олон нийт, оролцогч талуудад танилцуулах, сурталчлах зэргээр шинэчлэлийг эрчимжүүлэх | | |
| 5. | Өрсөлдөөн, худалдаа, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны чиг хандлагыг тодорхойлсон багц бодлогын баримт бичгийг эхний хувилбарыг захиалагчид танилцуулах | Гэрээ хийсний 5 долоо хоног |
| 6. | Өрсөлдөөн, худалдаа, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны салбарын эрх зүйн орчны шинэчлэлийн багц бодлогын баримт бичгийн талаар оролцогч талууд болох хувийн хэвшлийн төлөөлөл, төрийн, олон улсын байгууллага болон сонирхогч бусад талуудыг хамруулсан өргөн хүрээний цуврал хэлэлцүүлэг зохион байгуулах | |

| | | |
|---|--|---|
| 7. | Салбар бүрийн хэлэлцүүлгээс оролцогч талуудын саналыг авч тусган, захиалагч талд танилцуулан, хүлээлгэн өгөх | |
| В. Шинэ эрх зүйн орчны хүрээнд хэрэгжилтийг хангаж, үнэлгээ өгөх | | |
| 8. | Шинэчлэн боловсруулсан хууль тогтоомжийг оролцогч талуудад болон олон нийтэд таниулан сурталчлах, сургалт зохион байгуулах | Гэрээ хийсний 6 долоо хоногт |
| 9. | Өргөн барьсан хууль тогтоомжуудын дагуу оролцогч талуудад сургалт зохион байгуулах | Хууль өргөн баригдснаас хойш нэг долоо хоногт |

Зөвлөх үйлчилгээний багийн гишүүдэд тавигдах ерөнхий шаардлага:

- Судалгааны багийн хоёрны нэгээс доошгүй хувь нь өрсөлдөөн, гадаадын хөрөнгө оруулалт, худалдааны чиглэлээр бодлогын судалгаа хийж байсан туршлагатай,
- Судалгааны багийн 50 доошгүй хувь эдийн засгийн эсвэл хуулийн эрдмийн зэрэгтэй байх,

Зөвлөх компанид тавигдах шаардлага:

- Тодорхой салбарын эсвэл үндэсний өрсөлдөөн, хөрөнгө оруулалт, худалдааны асуудлаар бодлогын судалгаа эсвэл уулзалт, хэлэлцүүлэг хийж байсан туршлагатай.
- Бодлогын баримт бичиг боловсруулж байсан туршлагатай бол давуу тал болно.
- Олон нийтийн хэлэлцүүлэг, хурал зохион байгуулж, оролцогч талуудын эрх ашиг, санал хүсэлтийг ханган ажиллаж байсан 3-аас доошгүй гэрээний туршлагатай.
- Зөвлөх компани түншлэлээр оролцож болно.

IV. Тайлан бүтээгдэхүүн

| Но. | Тайлан | Тайлангийн агуулга | Тайлагнах хугацаа |
|------------|-----------------|--|---|
| 1 | Эхлэлийн тайлан | Ажлын даалгаврын А хэсгийн ажлын гүйцэтгэлд үндэслэн | Гэрээ байгуулснаас хойш 3 дахь долоо хоногт |
| 2 | Явцын тайлан | Ажлын даалгаврын Б хэсгийн ажлын гүйцэтгэлд үндэслэн | Гэрээ байгуулснаас хойш 5 дахь долоо хоногт |
| 3 | Эцсийн тайлан | Ажлын даалгаврын бүрэн гүйцэтгэлд үндэслэн | Гэрээ байгуулснаас хойш 7 дахь долоо хоногт |